



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/09

Мөрөн

Үнэлгээний хороо байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтууд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 43 дугаар тогтоол, Сангийн Сайдын 2014 оны 212 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн даргын 2017 оны 26 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу тус төвд улсын төсвийн урсгал зардлын хөрөнгөөр 11,425,100 (Арван нэгэн сая дөрвөн зуун хорин таван мянга нэг зуун) төгрөгийн төсөвт өртөг бүхий шатах, тослох материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог нэгдүгээр, 13,693,700 (Арван гурван сая зургаан зуун ерэн гурван мянга долоон зуун) төгрөгийн төсөвт өртөг бүхий түлш, халаалтын материал нийлүүлэх гүйцэтгэгч сонгох үнэлгээний хороог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Худалдан авах ажиллагааг хууль, журам, батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Болд)-д даалгасугай.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хатгал тосгоны Эрүүл мэндийн төвийн дарга (П.Цэрэндолгор)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2018 оны 1 дүгээр
сарын 8 -ны өдрийн А/09 дүгээр
захирамжийн 01 дүгээр хавсралт



**ХАТГАЛ ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ШАТАХ,
ТОСЛОХ МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**
(Төсөвт өртөг-11,425,100 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга


Гишүүд: Ч.Лхагвасүрэн-"Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо" төрийн бус
байгууллагын ажилтан

Ж.Балдандорж-Аймгийн Ногоочдын холбооны тэргүүн

Б.Жавзандулам-Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нягтлан бодогч

Нарийн бичгийн дарга: Ц.Бэхбаяр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн
хэлтсийн мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын 2018 оны 1 дүгээр
сарын 8-ны өдрийн А/09 дүгээр
захирамжийн 02 дугаар хавсралт



**ХАТГАЛ ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ТҮЛШ,
ХАЛААЛТЫН МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ
СОНГОХ ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**
(Төсөвт өртөг-13,693,700 төгрөг)

Үнэлгээний хорооны дарга: Б.Болд-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Гишүүд: Ч.Лхагвасүрэн-"Сайн засаглалыг дэмжигч иргэдийн оролцоо" төрийн бус
байгууллагын ажилтан

Ж.Балдандорж-Аймгийн Ногоочдын холбооны тэргүүн

Б.Жавзандулам-Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нягтлан бодогч

Нарийн бичгийн дарга: Ц.Бэхбаяр-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Өмчийн
хэлтсийн мэргэжилтэн